“Практикал даатгал” ХХК-ийн 2021 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 21-01/504 тоот хүсэлтэд үндэслэн гэнэтийн осол, эмчилгээний даатгалын хэлбэрт хамаарах “Хүнд өвчний даатгал”-ын бүтээгдэхүүнийг бүртгэв.

**Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мэдэгдэл огноо | Он | 2021 | Сар | 04 | Өдөр | |
| 2 | Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр | Практикал Даатгал ХК/<u>ХХК</u> | | | | | |
| 3 | Даатгалын бүтээгдэхүүний нэр | Хүнд өвчний даатгал | | | | | |
| 4 | Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр | Гэнэтийн осол, эмчилгээний даатгал | | | | | |
| 5 | Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр | Шийдвэрийн нэр | | Огноо | | Дугаар | |
| | | Журам батлах | | 2021.04.07 | | 21-02А/53 | |
| 6 | Цахимаар борлуулах эсэх | ☑ Тийм | | ☐ Үгүй | | | |
| 7 | Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч: | Овог | | Нэр | | | |
| | | Доржготов | | Уранцэцэг | | | |
| **Мэдээллийн төрлийг сонгоно уу.** | | | | | | | |
| 8 | ☑ Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах<br>☐ Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх | | | | | | |
| **Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл** | | | | | | | |
| 9 | Даатгалын зүйл | Даатгуулагч хүний эрүүл мэнд | | | | | |
| | Даатгалын үндсэн эрсдэл | Хүнд өвчин | | | | | |
| | Даатгалын нэмэлт эрсдэл | — | | | | | |
| | Даатгалын хураамжийн хувь, хэмжээ | 0,23% - 5.54% | | | | | |

# “ПРАКТИКАЛ ДААТГАЛ” ХХК-ИЙН БҮТЭЭГДЭХҮҮН БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТИЙГ ХЯНАСАН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2021.07.05 Улаанбаатар хот

Хорооны 2021 оны 25 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан Даатгалын багц дүрмийн 1 дүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 2.18-д “Даатгагч нь даатгалын бүтээгдэхүүнийг шинээр болон нөхцөл шаардлагыг шинэчлэн зах зээлд борлуулахаас өмнө тухай бүр энэ журмын 3 дугаар хавсралтад заасан зааврын дагуу СЗХ04008 мэдэгдлийн маягтыг бөглөж, энэ журмын 2 дугаар хавсралт (З)-д дурдсан баримт бичгийн бүрдлийг хавсарган Хороонд цахимаар мэдэгдэх ба тус бүтээгдэхүүний мэдээллийг Хороо өөрийн цахим хуудсанд байршуулсны дараа бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна гэж заасны дагуу “Практикал даатгал” ХХК-аас 2021 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 21-01/504 тоот албан бичгээр гэнэтийн осол, эмчилгээний даатгалын хэлбэрт хамаарах “Хүнд өвчний даатгал”-ын бүтээгдэхүүнийг бүртгүүлэх хүсэлт холбогдох баримт бичгийг ирүүлсэн.

БҮТЭЭГДЭХҮҮН БҮРТГҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛ:

| № | Тавигдах шаардлага | Баримт, бичгийн бүрдэл | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | 2.18.Даатгагч нь даатгалын бүтээгдэхүүнийг шинээр болон нөхцөл шаардлагыг шинэчлэн зах зээлд борлуулахаас өмнө тухай бүр энэ журмын 3 дугаар хавсралтад заасан зааврын дагуу СЗХ04008 мэдэгдлийн маягтыг бөглөж, энэ журмын 2 дугаар хавсралт (З)-д дурдсан баримт бичгийн бүрдлийг хавсарган Хороонд цахимаар мэдэгдэх ба тус бүтээгдэхүүний мэдээллийг Хороо өөрийн цахим хуудсанд байршуулсны | Тухайн даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр | Компанийн гүйцэтгэх захирлын 2021 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 21-02А/53 дугаар шийдвэр ирүүлсэн. |
| | | Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий танилцуулга | Хүнд өвчний даатгалын бүтээгдэхүүний ерөнхий танилцуулга ирүүлсэн. |
| | | Энэ журамд заасан даатгагчийн ТУЗ-өөр батлуулсан даатгалын | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн “Бүтээгдэхүүн боловсруулах журам” батлах тухай 2021/16 тоот |

| | | | |
|---|---|---|---|
| | дараа бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна. Хороо нь даатгалын бүтээгдэхүүний онцлог цар хүрээнээс хамааран тусгайлсан шаардлага тавьж болно | бүтээгдэхүүн боловсруулах журам | тогтоол ирүүлсэн. |

ДҮГНЭЛТ, САНАЛ

“Практикал даатгал” ХХК-аас ирүүлсэн гэнэтийн осол, эмчилгээний даатгалын хэлбэрт хамаарах “Хүнд өвчний даатгал”-ын бүтээгдэхүүнийг бүртгүүлэх хүсэлт, баримт бичгийг хянан үзээд холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангасан гэж дүгнэж байна.

Тус компани нь 2021.06.30-ны өдөр 11 хэлбэрт хамаарах 41 даатгалын бүтээгдэхүүнийг бүртгүүлсэн.

Иймд Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралын 2.18 */Даатгагч нь даатгалын бүтээгдэхүүнийг шинээр болон нөхцөл шаардлагыг шинэчлэн зах зээлд борлуулахаас өмнө тухай бүр энэ журмын 3 дугаар хавсралтад заасан зааврын дагуу СЗХ04008 мэдэгдлийн маягтыг бөглөж, энэ журмын 2 дугаар хавсралт (3)-д дурдсан баримт бичгийн бүрдлийг хавсарган Хороонд цахимаар мэдэгдэх ба тус бүтээгдэхүүний мэдээллийг Хороо өөрийн цахим хуудсанд байршуулсны дараа бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна. Хороо нь даатгалын бүтээгдэхүүний онцлог цар хүрээнээс хамааран тусгайлсан шаардлага тавьж болно/* гэж заасны дагуу “Практикал даатгал” ХХК-ийн гэнэтийн осол, эмчилгээний даатгалын хэлбэрт хамаарах “Хүнд өвчний даатгал”-ын бүтээгдэхүүнийг бүртгэх саналтай байна.

Хянасан:

Даатгалын газрын даргын үүргийг
түр орлон гүйцэтгэгч З.Батболд

Даатгалын газрын ахлах референт П.Цэрэндэжид

Боловсруулсан:

Даатгалын газрын ахлах мэргэжилтэн П.Мөнхсайхан